



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/116

Чингис хот

Хяналт шалгалт зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны "Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын журам" 318 дугаар тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны "Журам батлах тухай" А-166 дугаар, 2020 оны "Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай" А/577 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж байгаа Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Хяналт шалгалт -2020" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хуш модны самар үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн Өмнөдэлгэр, Батширээт сумдын ойн сангийн талбай, самар бэлтгэж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулахад 1880000 /нэг сая найман зуун наян мянга/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Хяналт шалгалтын ажлын удирдамж батлуулж, үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Дархантөр/ -д, шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д тус тус даалгасугай.

4. Хуш модны самар бэлтгэлд хяналт тавих ажлын хэсэг байгуулж хяналт шалгалт зохион байгуулахад хамтран ажиллах, холбогдох зардлыг сумын төсвөөс санхүүжүүлэхийг Батширээт, Өмнөдэлгэр сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

231010320

2.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны
...03... дугаар сарын 01 өдрийн ...116...
дугаар захирамжийн хавсралт

Зардлын төрөл, тоо хэмжээ

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/
1	Томилолт	5 хүн 9 хоног	1192500
2	Шатахуун	А-92 -425 л Мас.то -2 л	687500
Нийт зардал			1880000